



Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 09. сарын 26-ний өдрийн 1/33 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

СЕРВЕРИЙН ӨРӨӨНД АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Биеийн тамир, спортын улсын хорооны сервер, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг байрлуулах өрөө, тасалгаа, түүнд тавигдах шаардлага, түүнийг зүй зохицтой ашиглах, серверийн хэвийн үйл ажиллагааг хангах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Биеийн тамир, спортын улсын хорооны сервер компьютер, сүлжээний үндсэн төхөөрөмж нэг бүрийг эрх бүхий мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн /цаашид "мэргэжилтэн" гэх/ хариуцаж, энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй.

ХОЁР. СЕРВЕРИЙН ӨРӨӨ

2.1. Серверийн өрөөг нарны гэрэл шууд тусахгүй, ус чийггүй, халуун хүйтний хэлбэлзэл бага, хүчтэй соронзон орноос хол, тоосорхог бус орчинд сонгоно.

2.2. Серверийн өрөө нь холбогдох стандарт, техникийн нөхцөл, шаардлагад нийцсэн хөргөлтийн төхөөрөмж, кабель тараагч сувагчлал, цахилгаан тэжээлийн самбартай байна.

2.3. Серверийн өрөөнд дугаар бүхий зогсуурыг нэгэн шугамд, эгнээгээр жигд байрлуулна.

2.4. Серверийн өрөөний зогсуурт сервер компьютер, замчлагч, свич, кабел, тэжээлийн залгуур болон бусад шаардлагатай төхөөрөмжийг дугаарласан тавиур дээр байрлуулах шаардлагатай. Мөн тавиур дээрх тоног төхөөрөмжийн эд анги тус бүрийг дугаарласан байна.

2.5. Серверийн өрөө нь галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байна. Мөн хөдөлмөрийн болон техникийн аюулгүй ажиллагаатай холбоотой засвар үйлчилгээг хийх бүрэн гэрэлтүүлэгтэй байна.

2.6. Серверийн өрөө нь стандартын дагуу галын болон хөдөлгөөний дохиолол, хяналтын камер, чийгшүүлэгч төхөөрөмжэй байна.

2.7. Серверийн өрөөнд агааржуулалт, халаалтыг мэдрэх тоног төхөөрөмжийг суурилуулна. Эдгээр тоног төхөөрөмж нь 24 цагийн турш тогтмол ажиллагаатай байна.

2.8. Серверийн өрөөн дэх системүүдийн кабель шугамын (дотоод сүлжээ, E1, UTP кабелийн холболт г.м) холболтыг нягт нямбай хийнэ. Бүх кабель шошготой байна.

2.9. Кабелиудыг татаж байрлуулахдаа тухайн тоног төхөөрөмжтэй ажиллахад саад болохооргүй эмх цэгцтэй татна.

2.10. Цахилгаан зайд тэжээл хариуцсан инженерээр серверийн өрөөн дэх тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүчний нийт зарцуулалтыг тооцоолуулсан байна.

2.11. Серверийн өрөөнд шаардлагатай цахилгаан эрчим хүчний хэмжээг (чадал) цахилгааны автомат хайрцаг дээр бичнэ.

ГУРАВ. СЕРВЕРИЙН ӨРӨӨНД НЭВТРЭХ, БҮРТГЭЛ

3.1. Серверийн өрөө, тасалгаанд зөвхөн дараах албан тушаалтан нэвтэрнэ.
Үүнд:

- 3.1.1 Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- 3.1.2 Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга,
- 3.1.3 Салбарын мэдээллийн технологийн бодлогын зохицуулалт мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн,
- 3.1.4 Харьяа байгууллагын мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн
- 3.1.5 Байгууллагын дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн
- 3.1.6 “Серверийн өрөөнд нэвтрэх зөвшөөрөлийн маягт”-аар (Маягт 1) зөвшөөрөл авсан албан тушаалтан.

3.2. Серверийн өрөөнд нэвтэрсэн бүртгэлийг байгууллагын дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн бүртгэж, зөвшөөрөгдсөн болон зөвшөөрлөөр нэвтэрсэн албан хаагчийн бүртгэлийг “Серверийн өрөөний нэвтрэлтийн бүртгэлийн дэвтэр”-т хөтлөн бүртгэлийг хийн ажиллана.

3.3. Серверийн өрөөний хаалга электрон эсвэл соронзон цоожоор тоноглогдсон байх ба өрөөг эзэнгүй үед хаалгыг нь байнга түгжих, нэвтрэлт хийсэн тохиолдолд хаалгыг нээлттэй орхихгүй байна.

3.4. Серверийн өрөөнд нэвтрэлт хийгээгүй үед электрон болон соронзон цоожоор бүрэн цоожлох ба биет хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор лацыг ашиглана.

ДӨРӨВ. СЕРВЕРИЙН ӨРӨӨНД БАЙХ АНХААРУУЛАХ ТЭМДЭГНҮҮД

4.1. Серверийн өрөөн дэх мэдээллийн самбар дээр дараах мэдээллийг байрлуулна. Үүнд:

- 4.1.1. Серверийн өрөөнд идэж, уухыг хориглосон тэмдэг;
- 4.1.2. Серверийн өрөөнд зөвшөөрөлгүй орохыг хориглосон тэмдэг;
- 4.1.3. Чухал шаардлагатай утасны дугаарууд;
- 4.1.4. Төрийн захиргааны удирдлагын газрын даргын утасны дугаар;
- 4.1.5. Мэдээллийн технологийн мэргэжилтний утасны дугаар;
- 4.1.6. Онцгой тусlamжийн үйлчилгээний утасны дугаар

ТАВ. СЕРВЕРИЙН ӨРӨӨНД ДАРААХ ЗҮЙЛҮҮДИЙГ ХОРИГЛОНО

- 5.1. Зориулалтын бус тоног төхөөрөмж болон эд хогшил байлгах;
- 5.2. Өрөөнд нэвтрэх эрх бүхий болон зөвшөөрөгдөөгүй хүн нэвтрэхийг;
- 5.3. Шатамхай буюу тэсрэх дэлбэрэх зүйл оруулах;

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас сервер болон сүлжээний үндсэн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд ямар нэгэн гэмтэл saat ал гаргасан, хохирол учруулсан, серверийн өрөөний журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

--0o--